

Дундговь аймгийн Гурвансайхан сумын
иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны
01 дүгээр сарын 08-ны өдрийн 18 дугаар
тогтоолын хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

СУУГААНТ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” (2020 он) хуулинд богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаатай төлөвлөхөөр заасны дагуу Гурвансайхан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт” хөгжлийн зорилтот хөтөлбөр, Гурвансайхан хөгжил” 2019-2029 оны сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц төлөвлөгөө, иргэдийн саналыг тусган ашигласан.

Энэхүү бодлогын баримт бичиг нь хөгжлийн тэргүүлэх 6 бүлгийг хамарч байна.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бүлэг 17 чиглэл /салбар/ хүрээнд 17 зорилго, 40 зорилт 204 арга хэмжээг төлөвлөн гаргалаа.

АГУУЛГА

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

- 1.1 Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1 Эрүүл мэнд
2.2 Биеийн тамир, спорт
2.3 Боловсрол
2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
2.5 Үндэсний бахархал, өв соёл

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 3.1 Санхүү, төсвийн зохицуулалт
3.2 Уул уурхай, ашигт малтмал
3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
3.4 Аялал жуулчлал
3.5 Эрчим хүч

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба
4.3 Амар тайван, аюулгүй нийгэм
4.4 Батлан хамгаалах

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Ногоон хөгжил

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилго: Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулна.

Зорилт 1.1. Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2020 онд 80 хувь байсныг 2024 онд 90% хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 1.1.1. ААнэгж, ХХЭрхлэгч болон төрийн байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгааг хийж, сургалт зохион байгуулна.
- 1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.
- 1.1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүний нөөцийг нэмэгдүүлнэ.
- 1.1.4. Шаардлагатай, эм тариа, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодис, оношлуурын нөөцийг бүрдүүлнэ.
- 1.1.5. Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлаажуулна.
- 1.1.6. Гамшиг осол, онцгой байдал, шинэ сэргэж буй халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулж ажиллана.
- 1.1.7. “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагын гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд иргэдийн амьжиргаа, даван туулах чадавхыг бэхжүүлэх замаар орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн эрсдлийг бууруулна.

Зорилт 1.2. ЕБС-ийн сурагчдын теле хичээлийн хамрагдалтын хувийг 2020 онд хувь 60 байсныг 2024 онд 95 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 1.2.1. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд, эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна.
- 1.2.2. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.
- 1.2.3. Цар тахлын үед ЕБС-ийн сурагчдын теле хичээлийг тогтмол үзэлтийн хувийг нэмэгдүүлнэ.
- 1.2.4. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлгүй ажиллана.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Эрүүл мэнд

Зорилго 2.1: Эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ

Зорилт 2.1.1 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг 2019 онд 97% байсныг 2025 он гэхэд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.1.1.1. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлнэ.

2.1.1.2. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулна.

2.1.1.3. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж элэгний В,С вирусийн халдвартай иргэдийг дараагийн шатны эмчилгээнд хамруулж, хорт хавдраас урьдчилан сэргийлнэ.

2.1.1.4. Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулж, жил бүр үзлэгт хамруулна.

2.1.1.5. Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр зохион байгуулна.

2.1.1.6. Эрүүл мэндийн чиглэлийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сургалт сурталчилгааг эрчимжүүлнэ.

2.1.1.7. Эрүүл мэндийн байгууллагын гал тогоог шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тохижилт үйл ажиллагааг сайжруулна.

Зорилт 2.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

Арга хэмжээ:

2.1.2.1. Сумын Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх стандарт чанарын шаардлага хангасан амбулаторийн барилгыг шинээр барина.

2.1.2.2. Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.

2.1.2.3. Яаралтай тусламж үйлчилгээний чадавхийг сайржуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

2.1.2.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.5. Явуулын амбулаторийг жил бүр зохион байгуулж малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

2.1.2.6. Эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

Зорилт 2.1.3. Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 70 хувь байсныг 2024 он гэхэд 90 хувьд хүргэж, нийгмийн хамгааллыг сайжруулна.

Арга хэмжээ:

2.1.3.1. Эмч, эмнэлгийн ажилчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.3.2. Орон нутагт нэн шаардлагатай их эмч, сувилагч мэргэжилтнийг бэлтгэнэ.

2.2 Биеийн тамир, спорт

Зорилго 2.2: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 5-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 5 хувьтай байсныг 2024 онд 25 хувьд хүргэнэ.

Зорилт 2.2.1. Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 38 байсныг 2024 онд 120-д хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.2.1.1. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээг зохион байгуулж иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлнэ.
- 2.2.1.2. Сумын аваргашалгаруулах спортын төрөл бүрийн тэмцээн уралдааныг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.
- 2.2.1.3. Үндэсний спортыг хөгжүүлэх, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.2.1.4. Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн биеийн тамирын нийтийн Спортын талбайг шинээр байгуулна.
- 2.2.1.5. Спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын үйл ажиллагааг эрчимжүүлж дэмжин ажиллана.
- 2.2.1.6. Чийрэгжүүлэлт, фитнесийн төвтэй болно.
- 2.2.1.7. Орон нутагт аймаг болон бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулна.
- 2.2.1.8. Сумын төвд дугуйн талбайтай болно.

2.3 Боловсрол

Зорилго 2.3: Сургалтын чанарын үнэлгээний дундажийг 2019 онд 38 хувь байсныг 2024 онд 48 хувьд хүргэнэ. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 90 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Зорилт 2.3.1. Төгсөлтийн шалгалтын дундаж үнэлгээ 2020 онд 63 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ. Сургуулийн өмнөх боловсролын сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 2021-2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.3.1.1. СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.3.1.2. СӨБ-н сургуульд бэлтгэгдэх 5-н настай хүүхдүүдийг бүрэн хамруулна.
- 2.3.1.3. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.1.4. Насан туршийн боловсролын нэгжээр дамжуулан суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулна.
- 2.3.1.5. СӨБ болон ЕБС-ийн багш нарыг дотоод, гадаадад туршлага судлуулна.
- 2.3.1.6. Бүсийн хэмжээний олимпиад, уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулна.

Зорилт 2.3.2. СӨБ-ын хамран сургалтыг 100 хувьд, ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 100 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэж боловсролын салбарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ:

- 2.3.2.1. Сургуулийн дотуур байрны барилгыг ашиглалтад оруулж, тохижилт, амьдрахад таатай орчин нөхцлийг сайжруулна.

- 2.3.2.2. 1-2 настай хүүхдийг яслийн бүлэгт хамруулна.
- 2.3.2.3. Багш хөгжлийн төвийг шинээр байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.3.2.4. Сургуулийг орчин үеийн цахим туршилтын орчинд шилжүүлэх, зарлан мэдээллийн системтэй, дотоод сүлжээтэй болох ажил эхлүүлнэ.
- 2.3.2.5. Бага ангийн байгалийн ухааны кабинет байгуулна.
- 2.3.2.6. Сургуулийн өмнөх боловсролын урлаг, биеийн тамирын хичээлийг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.3.2.7. “Монгол бичиг үндэсний хөтөлбөр -3” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2.8. “Бүх нийтийн боловсролыг дэмжих хөтөлбөр”- ийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2.9. Хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг тохижуулна.
- 2.3.2.10. Бага насны хүүхдийн байгаль орчинтой танилцах туршилтын талбайтай болно.
- 2.3.2.11. СӨБ-ын байгууллагад хөгжмийн багш, эмчийн боловсон хүчний асуудлыг шийдвэрлэнэ.

2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Зорилго 2.4: Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлнэ.

Зорилт 2.4.1. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэний байнгын ажлын байрыг 2020 онд 21 байсныг 2024 онд 35 иргэн хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.4.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.
- 2.4.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Зорилт 2.4.2. 2020 онд ажилгүй байгаа 42 иргэдээс 2024 онд 35 иргэнийг ажлын байранд зуучлана.

Арга хэмжээ:

- 2.4.2.1. Ажилгүйдэлд бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс уул уурхай болон бусад ажлын байранд 35 иргэнийг зуучлна.
- 2.4.2.2. Иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж 15 ажлын байрыг шинээр бий болгоно.

Зорилт 2.4.3. 2019 онд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар 5хувь нь авч байсныг 2024 онд 70 хувиар нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 2.4.3.1. Нийгмийн халамжийн үйлчилгээ авагч иргэдийг нэрийн дансжуулж, цахим карттай холбоно.
- 2.4.3.2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн 60 хувь нь хүсэлтийг цахимаар авдаг болно.

Зорилт 2.4.4. Ахмадад ээлтэй байгууллага 2019 онд 2 байсныг 2024 онд 4-д хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.4.2.1. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношлогоонд тогтмол хамруулна.

2.4.2.2. Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, ахмадын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.4.2.3. Ахмадад ээлтэй байгууллагыг жил бүр шалгаруулна.

2.4.2.4. Ахмадын спортын болон урлагийн наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

Зорилт 2.4.5. Хүүхэд залуучууд, гэр бүлийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд анхаарч, авъяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ:

2.4.5.1. Бага насны Хүүхдийн тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулж, ногоон байгууламжийг бий болгоно.

2.4.5.2. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

2.4.5.3. Эрэгтэйчүүдийн холбоог байгуулж нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

2.4.5.4. Иргэдийн дунд соён гэгээрүүлэх чиглэлийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.4.5.5. СОУЗ-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах

2.4.5.6. Хүүхдийн чуулганыг жил бүр зохион байгуулна.

2.4.5.7. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт тавих ажлыг төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулна.

Зорилт 2.4.6. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

2.4.6.1. Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.

2.4.6.2. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдах боломжийг хэрэгжүүлж, иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.

2.4.6.3. Нийгмийн даатгалын орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь гаргаж өр, авлагагүй ажиллана.

2.5 Үндэсний бахархал, өв соёл

Зорилго 2.5: Уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэх, эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэд 2019 онд 258 байсныг 2024 онд 774-р нэмэгдүүлнэ.

Зорилт 2.5.1. Соёлын төвийн орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд соёлын үйлчилгээ хүргэх тав тухтай орчин бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

2.5.1.1. Соёлын төвийн ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.5.1.2. 250 хүний суудалтай Соёлын төвийн барилгыг шинээр барина.

2.5.1.3. Соёлын үйлчилгээний зөөврийн тоног төхөөрөмжтэй болно.

Зорилт 2.5.2. Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 40 хувь байгааг 2024 онд 70 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.2.1. Соёлын төвийг мэргэжлийн хөгжмийн багш, бүжгийн багш, соёлын өвийн мэргэжлийн боловсон хүчнээр хангана.

Зорилт 2.5.3. Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 6 байсныг 2024 онд 10-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.3.1. Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтанд авч хяналтыг сайжруулах, гэрээт хамгаалагчтай болно.

2.5.3.2. Сумын түүхт өв соёлыг хүүхэд багачууд, залуучуудад сурталчилна.

2.5.3.3. Сумын музейтэй болно.

2.5.3.4. “Адуучин” тэмцээнийг зохион байгуулна.

2.5.3.5. “Тэмээний баяр” –ыг зохион байгуулна.

2.5.3.6. “Уяхан замбуу тивийн наран” эвент наадамд оролцоно.

2.5.3.7. Иргэдийн дунд Соён гэгээрүүлэх лекц, яриаг зохион байгуулна.

2.5.3.8. Гурвансайхан сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.

2.5.3.9. Иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.3.10. Албан байгууллага, гудамж талбайн нэр хаягийг монгол бичгээр бичиж байршуулна

2.5.3.11. Явуулын номын сан, дуудлагын номын санг ажиллуулна.

2.5.3.12. Цагаан идээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.

2.5.3.13. “Нүүдлийн соёлын төв” явуулын соёлын үйлчилгээг зохион байгуулна.

2.5.3.14. Баг, байгууллагуудын дунд урлагийн наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго 3.1: Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 156476,4 төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж 2024 онд 160 саяд хүргэнэ.

Зорилт 3.1.1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулалт 2020 онд 100 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.1.1. Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлнэ.

3.1.1.2. Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь ханган биелүүлнэ.

Зорилт 3.1.2. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.

Арга хэмжээ:

- 3.1.2.1. Орон нутгийн аж ахуйн нэгжүүд, нөхөрлөлийн бүлд худалдан авах ажиллагаанд цахим хэлбэрээр оролцох мэдлэг олгох сургалт зохион байгуулна.
- 3.1.2.2. Тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймаг, сумын вэб сайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлнэ.
- 3.1.2.3. Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах АЗ-н сургалтанд иргэдийг хамруулж гэрчилгээжүүлэх, үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулна.
- 3.1.2.4. Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron.putag.mn сайтад тухай бүр мэдээлнэ.
- 3.1.2.5. Худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж хэрэгжиж буй ажлын гэрээний биелэлтэд хамтарсан ажлын хэсэг хүлээж авдаг тогтолцоог бий болгож, гэрээний хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1.3. Сумыг бие даан хөгжих эдийн засаг, төсөв санхүү, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 3.1.3.1. Төсвийн тухай хуулийн хүрээнд сумын ОНХСангийн эх үүсвэрийг жил бүр нэмэгдүүлнэ.
- 3.1.3.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр суманд зайлшгүй хэрэгжүүлэх ажлын хийлгэнэ.
- 3.1.3.3. Орон нутгийн өмчит албыг байгуулна.

Зорилт 3.1.4. Төрийн болон орон нутгийн өмч эзмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

Арга хэмжээ:

- 3.1.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл, мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгоно.
- 3.1.4.2. Орон нутгийн өмчийн бүртгэлээс хасах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгоно.
- 3.1.4.3. Улсын төсөв болон дотоод, гадаадын хөрөнгөөр бий болсон хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллана.

Зорилт 3.1.5. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, сумын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 3.1.5.1. Төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, хэрэгжилтийг улирал тутам тооцох замаар төсвийн алдагдалгүй ажиллана.
- 3.1.5.2. Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансанд мэдээллийг байршуулж буй эсэхэд тогтмол хяналт явуулж, үр дүнг нийтэд мэдээлнэ.

3.2 Уул уурхай, ашигт малтмал

Зорилго 3.2: Уул уурхайн хайгуул, ашиглалтын лицензтэй аж ахуй нэгжүүдэд хяналт тавих тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орох орлого 2020 онд 176.041.533 төгрөг байгааг 2024 онд 200 сая төгрөгт хувьд хүргэнэ.

Зорилт 3.2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээг байгуулж гэрээ болон үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулна.

Арга хэмжээ:

3.2.1.1. Ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн үйл ажиллагаанд нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулна.

3.2.1.2. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж иргэдийг ажлын байраар ханган, бүтээн байгуулалтыг бий болгоно.

3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Зорилго 3.3: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 30 сая төгрөг байсныг 2024 онд 45 сая төгрөгт хүргэнэ.

Зорилт 3.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ 2020 онд 2 хувь байсныг 2024 онд 8-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.

Арга хэмжээ:

3.3.1.1. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн нутгийн онцлогийг шингээсэн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлан, зах зээлд нийлүүлнэ.

3.3.1.2. Ноос, арьс, ширний анхан шатны үйлдвэр, цехийг байгуулах санал санаачилгыг дэмжин ажиллана.

3.3.1.3. Хөрсний судалгаа, шинжилгээг хийлгэж талбайг бэлтгэн иргэдийн төмс, хүнсний ногоо тарих нөхцөлийг бий болгоно.

3.3.1.4. Тэжээлийн ургамал тариалах иргэн, ААНэгжийг дэмжинэ.

3.3.1.5. Гүн өрмийн худгийг шинээр нэмэгдүүлнэ.

3.3.1.6. Мал нядалгааны цэгийг бий болгоно.

3.3.1.7. Хүлэмжний аж ахуй эрхлэх байгууллага, ААНэгж, иргэдийг дэмжин ажиллана.

3.3.1.8. ЖДҮ-ийн барилгын үйл ажиллагаа явуулах, ажиллах нөхцөлийг боломжийг бүрдүүлнэ.

3.3.1.9. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын дагуу сумын аюулгүйн нөөцөд шаардлагатай өвс тэжээлийг бэлтгэнэ.

3.3.1.10. ОУ-ын төслийн байгууллагуудтай Мал аж ахуй, ЖДҮ, түншлэлийн харилцааг хөгжүүлэн, хамтран ажиллана.

3.3.1.11. Сүүний чиглэлийн Үхрийн фермерийг байгуулах ААНэгж, иргэнийг дэмжин ажиллана.

3.3.1.12. Цагаан идээ, шинэ ногооны өдөрлөг, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж зах зээлд сурталчилна.

3.3.1.13. Зоорины ашиглалтыг сайжруулна.

Зорилт 3.3.2. Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 800 малд шинээр нэвтрүүлнэ.

Арга хэмжээ:

3.3.2.1. Дутагдалтай байгаа стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бойжуулж мал сүргийг үе шаттайгаар сайжруулна.

3.3.2.2. Сумын хэмжээнд тэмээн сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлнэ.

3.3.2.3. Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулна.

Зорилт 3.3.3. Бэлчээрийн даац хэтрэлтийг үе шаттайгаар бууруулж, нөхөн сэргээх талбайн хэмжээг 2024 онд 2 га-р нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 3.3.3.1. Малын тэжээлийн ургамлыг 1 га талбайд тариална.
- 3.3.3.2. Бэлчээр хаших журмыг батлуулна.
- 3.3.3.3. Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулна.
- 3.3.3.4. Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулна.
- 3.3.3.5. Бэлчээрийн менежментийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Зорилт 3.3.4. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан малын тоо 2020 онд 50000 толгой буюу нийт мал сүргийн 16,2 хувь байгааг 2024 онд нийт малын 30 хувьд хүргэж бууруулна.

Арга хэмжээ:

- 3.3.4.1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг графикт хугацаанд нь бүрэн хамруулна.
- 3.3.4.2. Мал угаалгын ванныг баг бүрт бий болгоно.
- 3.3.4.3. Мал эмнэлгийн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.
- 3.3.4.4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ байгуулан хяналт тавьж ажиллана.
- 3.3.4.5. Мал эмнэлэг, ХАА-н чиглэлээр суралцах боловсон хүчнийг дэмжин, бэлтгэнэ

Зорилт 3.3.5. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, боловсон хүчний чадавхийг сайжруулна.

Арга хэмжээ:

- 3.3.5.1. Хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэнэ.
- 3.3.5.2. Суманд хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
- 3.3.5.3. Цөөн малтай залуу малчдыг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулна.
- 3.3.5.4. Залуу малчдыг мал маллах уламжлалт арга ухаанд сургах ажлыг зохион байгуулна.

3.4 Аялал жуулчлал

Зорилго: Аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжин, гадаад дотоодын жуулчдын тоог 2024 онд 1500-д хүргэнэ.

Зорилт 3.4.1. Уламжлалт өв соёл, зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээнд оролцоно.

Арга хэмжээ:

- 3.4.1.1. Орон нутгийн байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж иргэнийг дэмжин ажиллана.
- 3.4.1.2. Аймаг бүсийн аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, орон нутгаа сурталчилна.
- 3.4.1.3. Орон нутгаа сурталчилсан, онцлогийг илтгэсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх иргэдийг дэмжин ажиллана.
- 3.4.1.4. Жуулчдад үзүүлэх уламжлалт зан чанар бүтээлийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

3.5 Эрчим хүч

Зорилго 3.5: Цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.5.1. Сумын төвийн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангаж хяналт тавьж ажиллах

Арга хэмжээ:

3.5.1.1. Баяжих хорооллын эрчим хүч татах асуудлыг шийдвэрлэнэ.

3.5.1.2. Цахилгаан ашиглалтын хяналтын сумын зөвлөлийг байгуулж ажиллана.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ

Зорилго 4.1: Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 70 хувьтай байгааг 2024 онд 90 хувьтай болгож нэмэгдүүлнэ.

Зорилт 4.1.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, ил тод, нээлттэй болгож, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэдээ дээдэлсэн үйлчилгээг эрхэмлэнэ.

Арга хэмжээ:

4.1.1.1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах ажлыг тогтмолжуулж иргэдтэй уулзах уулзалт, өдөрлөгийг зохион байгуулна.

4.1.1.2. “Цахим төр-Ухаалаг Дундговь” цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.3. ЗДТГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хэвлэмэл байдлаар иргэдэд боломжит хувилбараар хүргэж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг сурталчилна.

4.1.1.4. Цаг үеийн онцгой нөхцөл байдлын үед төрийн албыг онлайнаар гүйцэтгэх, видео хурал хийх нөхцөл боломжийг бүрдүүлж, төрийн албаны шуурхай байдлыг хангана

4.1.1.5. Архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх

4.1.1.6. Архивт нягтруулсан шүүгээг авч бусад техник хэрэгсэл, тоногтөхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

4.1.1.7. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай хянаж, түүнд тавих хяналтыг сайжруулж, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллана.

4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

Зорилго 4.2: Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 1хувьтай байсныг 2024 онд 100%-иар бууруулна.

Зорилт 4.2.1. Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 2 хувь байсныг 2024 онд 100 хувиар бууруулна.

Арга хэмжээ:

- 4.2.1.1. Төрийн албаны бүх шатанд хариуцлагыг эрхэмлэн , иргэнд чиглэсэн , хүнд сурталгүй, ил тод нээлттэй төрийн албыг бий болгоно.
- 4.2.1.2. Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах
- 4.2.1.3. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэргүүний ажиллагаатай төрийн албан хаагчдын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, алдаршуулах ажлыг зохион байгуулна.
- 4.2.1.4. Төрийн байгууллагын бүх шатанд төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдүүлнэ.
- 4.2.1.5. Төрийн албан хаагчдад манлайллын ур чадвар, хандлага сэтгэлгээ төлөвшүүлэх сургалт зохион байгуулна
- 4.2.1.6. Төрийн жинхэнэ албан хаагч болон удирдах ажилтны сул орон тоо гарсан тохиолдолд холбогдох хууль журмын дагуу ажлын байрны захиалгыг ТАСЗөвлөлд хүргүүлэн ажиллана.
- 4.2.1.7. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож ажиллана.
- 4.2.1.8. Бүх нийтэд Хүний эрх, жендерийн боловсрол олгох сургалт мэдээллийг зохион байгуулж, жендерийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт 4.2.2. Төрийн албаны ил тод байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлнэ.

Арга хэмжээ:

- 4.2.2.1. Бүх шатанд шийдвэр боловсруулах, батлах, хэрэгжүүлэхдээ иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн саналыг сонсох, тусгах, зөвлөлдөх, оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.2.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, авлига , ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 4.2.2.3. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангахад чиглэсэнхууль зүйн тусламж, үйлчилгээ, сургалт, суртчилгааг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд зохион байгуулна
- 4.2.2.4. Хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл тайлбар, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын цахим сайтад бүргэж ажиллана.
- 4.2.2.5. Сумын мэдээллийн сонинтой болно.

Зорилт 4.2.3. Эрх зүйн сургалт сурталчилгааг эрчимжүүлж, хууль тогтоомж, захиргааны актын сан бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

- 4.2.3.1. Хүний эрхийг хангахад чиглэсэн хууль зүйг тусламж, үйлчилгээ, сургалт сурталчилгааг жил бүр зохион байгуулж нийт иргэдийн 30-с доошгүй хувийг хамруулна.
- 4.2.3.2. "Эрх зүйн хөтөч" нар болон багийн үйл ажиллагааг дэмжин, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, сургалт мэдээллийг тасралтгүй боломжит хэлбэрээр зохион байгуулна.
- 4.2.3.3. Иргэний танхимын үйл ажиллагааг тогмтолжуулж, үйлчилгээний төрөл, чанарт анхаарч ИТХ-тай хамтран ажиллана.
- 4.2.3.4. Хүний эрхийг хамгаалах, төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үйлчилгээг үзүүлнэ.

4.2.4.5. Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын хувийн хэрэг бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

4.3 Амар тайван, аюулгүй нийгэм

Зорилго 4.3: Гэмт хэргийн гаралт 2020 онд 8 байсныг 2024 онд 70-аас доошгүй хувиар бууруулж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

Зорилт 4.3.1. Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг барагдуулах бодит нөхцлийг дээшлүүлж, 2019 онд 80 хувьтай байгааг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.1.1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд малчдын бүлэг, нөхөрлөлийнсонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

4.3.1.2. Цагдаагийн кабонд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах нөхцөл боломжийг бүрдүүлж, эмэгтэйчүүд хүүхдүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх ажлыг хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

4.3.1.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээ, тоног төхөөрөмжийг байршуулж ажиллана.

4.3.1.4. Төрийн байгууллага болон ТББайгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

Зорилт 4.3.2. Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 40%-тай байсныг 2024 онд 60%-д хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.2.1. Аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг малчид, иргэдэд шуурхай хүргэх техникийн бэлэн байдлыг хангана.

4.3.2.2. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангаж, чадавхыг нэмэгдүүлж, дадлага сургууль үзлэг зохион байгуулна.

4.3.2.3. Гамшгаас хамгаалах мэдээллийн зарлан дохиоллын тоног төхөөрөмжтэй болно.

Зорилт 4.3.2. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 90 хувьтай байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.2.1. Цагдаагийн албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

4.3.2.2. Цагдаагийн кабонд шаардлагатай засвар үйлчилгээг хийнэ.

4.3.2.3. Сумын нэгдсэн хяналтын камерийг нэмэгдүүлж, хяналтыг цагдаагийн кабонд төвлөрүүлнэ

4.4 Батлан хамгаалах

Зорилго 4.4: Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

Зорилт 4.4.1. Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамж 2020 онд 60 хувь байсныг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.4.1.1. Хүүхэд залуучуудад “Эх оронч” үндэсний хөтөлбөрийг сурталчилна.

4.4.1.2. Цэргийн жинхэнэ албанд татагчдын өвчлөлийн судалгааг гаргаж, эрүүлжүүлэх арга хэмжээг сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

4.4.1.3. Дайчилгааны төлөвлөгөө, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг жил бүр тодотгож баталгаажуулах, даалгаваржуулах дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг ханган ажиллана.

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Ногоон хөгжил

Зорилго 5.1: Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөнсэргээх, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт 5.1.1. Иргэдийн ая тухтай амьдрах цэвэр, эрүүл, эко орчныг бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

5.1.1.1. Сумын хогийн цэгийг сайжруулна.

5.1.1.2. Сумын төвийн зам дагуу стандартын хогийн савтай болно.

5.1.1.3. Усалгааны системтэй болно.

5.1.1.4. Сумын төвийн тэжээвэр мал амьтантай айл өрхийн асуудыг цэгцэлнэ.

5.1.1.5. Ахуйн хог хаягдлыг ангилдаг цэгийг бий болгоно.

5.1.1.6. Усан оргилуур бүхий Цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

5.1.1.7. Золбин нохой, муур устгах ажлыг жил бүр зохион байгуулна.

5.1.1.8. Ундны усны худгийн орчины эрүүл ахуй, хамгаалалтыг сайжруулна.

5.1.1.9. Булгийн эхийг хашиж, хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.

5.1.1.10. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.1.1.11. Экологийн боловсрол олгох сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

5.1.1.12. Сумын төвийн зам дагуу Ногоон байгууламжийг хашаажуулна.

5.1.1.13. Засмал замын даланг эко хавтангаар өнгөлнө.

5.1.1.14. Наадмын талбайн морь барианы газрын тохижилтыг сайжруулна.

5.1.1.15. Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна.

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

Зорилго 6.1: Дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд хэсэгчилсэн болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоотойгоор амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт 6.1.1. Иргэдийн оролцоотой сумын хөгжил бүтээн байгуулалт, ажиллаж амьдрах цэвэр, тохилог орчинг бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

- 6.1.1.1. Аймгийн Зүүн бүсийн төв сум болно.
- 6.1.1.2. Сумын хөгжлийн төлөвлөгөөг шинэчилнэ.
- 6.1.1.3. Сумын төвийн ундны усны худгийг цахим худаг болгоно.
- 6.1.1.4. Сумын төвд нийтийн халуун усыг шинээр барина.
- 6.1.1.3. Орон нутгийн өмчит албыг байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 6.1.1.4. Сумын Угтах, үдэх хаалгыг шинэчлэн хийнэ.
- 6.1.1.5. 8 айлын Түрээсийн орон сууцыг барина.
- 6.1.1.6. Дэд бүтцийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ковш, экскавотар техниктэй болно.
- 6.1.1.7. Хог ачих, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцлагажуулж, тогтмолжуулна.
- 6.1.1.8. Төрийн бүхий л үйл ажиллагаанд ашиглагдах автобустай болно.
- 6.1.1.9. Дотуур байрыг засварлаж, төрийн албан хаагчдын байр болгоно.

Зорилт 6.1.2. Сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж санал авсан иргэдийн тоо 2020 онд 360 байсныг 2024 онд 50%-иар нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 6.1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлж, мэдээллийн тоог нэмэгдүүлнэ.
- 6.1.2.2. Тухайн онд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron nutag.mn сайтад тухай бүр байршуулна.

-----oOo-----